



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2017/10



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 10 дугаар сарын байдлаар)

### Нэг. Нийгмийн үзүүлэлт



#### 1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 10 сард 1134 эх амаржиж, 1139 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 63(5.9%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 61(5.7%)-ээр, 330 хүн нас барсан нь 41(14.2%)-ээр тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 809 болж өмнөх оны мөн үеэс 20(2.5%)-оор өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 16.9, нас баралт 4.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.3 пунктээр өсч, нас баралт 0.4 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 10 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 13 байгаа нь өмнөх оны мөн үеэс 7-оор илүү юм.



#### 1.2 Эрүүл мэнд


2018 оны 10 сарын байдлаар 299.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар, 13.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар, 11.2 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар тус тус өсчээ..

2018 оны 10 сард 1344 эх жирэмсний хяналтанд орсны 89.1 хувь буюу 1197 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 16.3 мянган удаа гарсны 2.7 мянга буюу 16.6 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 6.5 хувиар, алсын дуудлага 3.8 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 2620 хүн бэртэж, 81 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 374(16.7%)-өөр, нас барсан хүний тоо 10(14.1%)-аар нэмэгджээ.

*Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 10 сард*



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд осол, гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 24.5 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 24.8 хувь, хавдар 19.7 хувь, хоол шингээх эрхтний өвчин 10.3 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 5.8 хувь, бусад төрлийн өвчин 14.8 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 584 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22(3.6%)-оор буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад бусад төрлийн өвчин 57.7 хувиар буурсан нь нөлөөлжээ.




### 1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 10 сарын эцэст 1016 болсны 996 (98.0%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 20 (1.9%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 296 (22.5 %) хүнээр буурч, өмнөх сараас 51(5.1%) хүнээр буурсан байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 491 (48.3%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 560 (55.1%) нь Сайншанд суманд, 139 (13.7%) нь Замын-Үүд суманд байна.

Боловсролын түвшинг харахад 63.3 хувь нь бүрэн дунд, 16.7 хувь нь дээд, 6.5 хувь нь бүрэн бус дунд, 6.2 хувь нь техник болон мэргэжлийн, 3.2 хувь нь тусгай дунд, 2.9 хувь нь боловсролгүй, 1.1 хувь нь бага боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 10-р сард



Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 2422 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 443 иргэн ажилд зуучлагдан орж, 44 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 617 ажлын байрны 58 (9.4%) нь төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, 142 (23.0%) нь бусад салбарын, 155 (25.1%) нь үйлчилгээний, 199 (32.2%) нь уул уурхайн олборлолтын салбарын захиалга байна. Ажил хайгч 538 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 226 (42.0%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон салбараар






#### 1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 10 сард 26668.1 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4386.7(19.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 4386.7 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 3398.1(25.4%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 568.0(25.6%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 385.9(25.4%) сая төгрөгөөр өссөн нь голлон өлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 10 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 35808.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 3314.4 (10.2%) сая төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 26949.9 (75.4%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4030.4(11.3%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 2111.9(5.9%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2022.3(5.6%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 693.5(1.9%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг







Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 10 сард нийгмийн халамжийн сангаас 23281 иргэнд 6647.5 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 5485 (30.8%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 1930.4 (40.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд цалинтай ээж хөтөлбөрт 3769 иргэнд 1500.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1363 хүн хамрагдсан нь өмнөх оноос 20 (1.4%)-ээр буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 211.4 (12.5%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тусламжид 1069 иргэнд 631.2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 1010 иргэнд 523.7 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 8621 иргэнд хамруулж 916.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 11218 иргэнд 2678.8 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/





## 1.5 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 10 сарын байдлаар 431 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 108 хүн гэмтэж, 17 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 158(26.8%)-аар, нас барсан хүний тоо 11(39.3%)-аар, гэмтсэн хүний тоо 73(40.3%) -аар буурсан байна.

Төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг нэмэгдэж бусад төрлийн гэмт хэрэг буурчээ.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 42.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 26.0 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 8.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг, 5.1 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 53 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89(62.7%) -оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Иххэт, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурч, Алтанширээ, Дэлгэрэх сумд өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 7678.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3535.9(85.3) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 6658.5(86.7%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 114(26.5%) нь гэр сууцандаа, 68(15.8%) нь гудамж олон нийтийн газарт, 53(12.3%) нь согтуугаар, 61(14.2%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 20(4.6%) бүлэглэн, 146 (33.9%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1110 хүн эрүүлжүүлэгдэж, 230 хүн баривчлагджээ.



Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 10 сар



## Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



### 2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 1168.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 210.5(22.0%) тэрбум төгрөгөөр, цэвэр зарлага 1110.9 тэрбум төгрөг болж 202.3(22.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017-2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 95.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1368.7 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1407.4 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 3.3(5.0%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 21.1 (28.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 10 дугаар сарын эцэст 3209.0 сая төгрөг болж, өмнөх сараас 737.1(18.7%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 705.3 (28.2%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.2 хувийг эзэлж, өмнөх сараас 0.4 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр тус тус буурчээ.

Чанаргүй зээл 10 дугаар сарын эцэст 7523,9 сая төгрөг болж өмнөх сараас 158.9(2.2%) сая төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 396.5 (5.0%) сая төгрөгөөр буурчээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.10 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.10 сард



## 2.2 Орон нутгийн төсөв

2018 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсөвт 22414.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 104.0 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 20.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 76.4 хувийг татварын, 23.6 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 10-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 4585.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 877.0 (23.7%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 1216.2 (36.1%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



## 2.3 Үнэ


Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2018 оны 10 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар тус тус өсчээ.


**Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.2 хувиар өсөхөд:** согтууруулах ундаа, тамхи 1.0 хувь, хувцас бөс бараа, гутал 0.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.5 хувь, эм, тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.7 хувь, тээвэр 1.2 хувь, зочид

буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 0.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 2.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 10 дугаар сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 10 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



### Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



#### 3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 10 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 72.9 хувь буюу 604.2 мянган толгой мал төллөж, төл бойжилт 97.9 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 31.6(5.4%) мянган толгойгоор, төл бойжилт 17.5(2.9%) мянган толгойгоор илүү юм.



Эхний 10-н сарын байдлаар 10291 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 8.1(4.6 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд Дэлгэрэх, Иххэт сумдын нутаг дэвсгэрээр 4-р сард нойтон цас орж, хүчтэй цасан шуурга шуурч байгалийн онц аюултай үзэгдэл болж, Дэлгэрэх суманд 2.2 мянган толгой мал, Иххэт суманд 2.2 мянган толгой мал, Даланжаргалан суманд 1.2 мянган толгой мал хорогдсон нь голлон нөлөөлсөн байна.

2018 онд 57.7 га талбайгаас 298.7 тонн ургац хураан авсан нь нийт тариалсан талбайн 30.0 хувийг эзэлж байна. Хураан авсан ургацыг өмнө оны мөн үетэй харьцуулахад 123.2(29.8%) тонноор буурчээ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар эр хонь 100.0-180.0 мян.төг, эр ямаа 60.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 10 сард аж үйлдвэрийн салбарт 185095.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 267795.6 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 53671.1 (40.8%) сая төгрөгөөр, борлуулалт 60152.0 (29.0%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2018 оны эхний 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 40.8 хувиар өсөхөд уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 27447.1 сая төгрөгөөр, боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 26360.1 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2.6 хувийг төрийн, 97.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 2.6 хувь, компани 97.1 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал сувагжуулалт 89.4 мян.м3-ээр, ус түгээлт 85.2 мян.м3-аар, нарийн боов 20.1 тонноор, нүүрс 140.0 мян.тонноор, вакуум цонх 879.3 м2-аар, цемент 316.7 мян.тонноор, модон эдлэл 19218.9 мян.төгрөгөөр, дээл 128 ширхэгээр, бетон зуурмаг 10030.5 м3-ээр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин

#### Цаг уур

2018 оны 10 дугаар сарын дундаж агаарын температур Хөвсгөл, Хатанбулаг сумдад 6.4-6.6 хэм, бусад сумдын нутгаар 4.3-5.7 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө 20-26 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Өргөн суманд ОЖД-аас 1.8- градусаар хүйтэн, Алтанширээ, Иххэт сумдад ОЖД-аас 1.3-2 градусаар дулаан, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 8-11 хэм хүйтэн, өдөртөө 33-39 хэм дулаан байв.



10 дугаар сард Замын-Үүд, Дэлгэрэх, Алтанширээ сумдад 0.0 мм, Сайншанд суманд 0.1 мм, Мандах, Эрдэнэ сумдад 0.5 мм, Иххэт суманд 1.0 мм бороо орсон нь нийт нутгаар ОЖД-аас бага байв.

Энэ сард салхины хамгийн их хурд Алтанширээ суманд 14 м/с, бусад сумдын нутгаар 16-22 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо 6-14 өдөр байв.



## АГУУЛГА

### II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл

(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

#### Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

#### Хоёр. Боловсрол

- 2.1 Боловсролын үзүүлэлтүүд

#### Гурав. Хөдөлмөр эрхлэлт

- 3.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 3.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 3.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 3.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 3.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 3.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар

#### Дөрөв. Нийгмийн даатгал, халамж

- 4.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 4.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 4.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

#### Тав. Гэмт хэрэг

- 5.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 5.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

#### Зургаа. Мөнгө, зээл

- 6.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 6.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст

#### Долоо. Орон нутгийн төсөв

- 7.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 7.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 7.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 7.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

#### Найм. Үнэ

- 8.1 Хэрэглээний үнийн индекс
- 8.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф

- 8.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

#### Ес. Хөдөө аж ахуй

- 9.2 Том малын зүй бус хорогдол
- 9.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 9.4 Малын үнийн судалгаа, сумаар

#### Арав. Аж үйлдвэр

- 10.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 10.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа

#### Арван нэг. Байгаль орчин

- 11.1 Цаг уурын үзүүлэлт

#### Тэмдэглэлийн тайлбар :

- ( ,, ) - тухайн тоо, баримт байхгүй
- ( 0 ) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- ( х ) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- ( . ) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018 2017
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	69.0	0.8	101.2
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	1297	1205	1078	1139	61	105.7
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	275	304	289	330	41	114.2
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	1022	901	789	809	20	102.5
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	10	9	6	13	7	216.7
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	7.5	5.6	11.4	5.8	205.1
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	733	1470	609	587	-22	96.4
- 10000 хүнд ногдох	тоо	116.1	220.7	89.3	86	-3	96.4
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 135	1 047	1 312	1 016	- 296	77.4
- Үүнээс эмэгтэй	тоо	673	552	660	491	- 169	74.4
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	263	262	309	235	- 74	76.1
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	883	443	449	314	-135	69.9
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	883	333	449	168	-281	37.4
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	110	0	146	146	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	460	546	589	431	-158	73.2
- 10000 хүнд ногдох ***	тоо	111	128	137	100	-37	72.8
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	532414	469517	586705	604177	17472	103
- Унага	толгой	6048	6005	6668	6552	-116	98
- Тугал	толгой	19901	12817	21649	21757	108	100
- Ботго	толгой	17496	12753	16615	17910	1295	108
- Хурга	толгой	250294	236632	286903	298453	11550	104
- Ишиг	толгой	238675	201310	254870	259505	4635	102
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	7496.4	13608.5	131424.1	185095.2	53671.1	140.8
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	7412.2	8530.6	207643.6	267795.6	60152.0	129.0

\* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

### НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

#### 1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 10 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-X	2018 I-X	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	288.2	299.3	11.1	103.9
2. Ор хоног	мян.хүн	93.8	99.0	5.2	105.5
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	9.5	11.2	1.7	117.9
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	13.2	13.8	0.6	104.5
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	15.3	16.3	1	106.5
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.6	2.7	0.1	103.8
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2246	2620	374	116.7
Үүнээс: нас баралт	хүн	71	81	10	114.1
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1304	1344	40	103.1
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1122	1197	75	106.7
8. Амаржсан эх	хүн	1071	1134	63	105.9
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	4	3	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	9	13	4	144.4

#### 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 10 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				тоо	тоо
Дүн	1130	0	1135	12	4
Айраг					
Алтанширээ	1				
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	1		1		1
Саиншанд	913		917	7	1
Замын - Үүд	212		214	4	2



## 1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-X	2018 I-X	Өсөлт	
	тоо			хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	609	587	-22	96.4
Вируст гепатит	8	8	0	100.0
Сүрьеэ	77	83	6	107.8
Тэмбүү	75	107	32	142.7
Заг хүйтэн	110	164	54	149.1
Трихоминиаз	64	70	6	109.4
Цусан суулга	34	53	19	155.9
Бусад	241	102	-139	42.3

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

## ХОЁР. БОЛОВСРОЛ

## 2.1 БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2017-2018	2018-2019	Өсөлт	
				тоо	хувь
1. ЕБС-Элсэлт	тоо	3212	3551	339	110.6
Үүнээс: Бага боловсролоор элсэгчид	тоо	1553	1621	68	104.4
Сурагчид	тоо	12759	13009	250	102.0
Үндсэн багш	тоо	625	629	4	100.6
2. МСҮТ - Элсэлт	тоо	360	516	156	143.3
Нийт сурагчид	тоо	597	693	96	116.1
Үндсэн багш	тоо	34	37	3	108.8
Хамрагдсан ААН	тоо	2	2	0	100.0
3. АШУҮИС - Элсэлт	тоо	141	140	-1	99.3
-Анагаах, суурь сургалт /бакалавр/	тоо	70	70	0	100.0
-Сувилахуй /бакалавр/	тоо	15	14	-1	93.3
-Эх барихуй /бакалавр/	тоо	4			
-Бусад	тоо	52	56	4	107.7
Нийт оюутан	тоо	627	566	-61	90.3
Үндсэн багш	тоо	60	56	-4	93.3
4. СӨБ - Элсэлт	тоо	1637	1532	-105	93.6
Хамрагдаж байгаа хүүхэд	тоо	5354	5321	-33	99.4
Үндсэн багш	тоо	167	170	3	101.8



## 3.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 10 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015.X	2016.X	2017.X	2018.X	2018.X	2018.X
	хүний тоо				хувь	
ДҮН	1 087	1 047	1 312	1 016	93.5	77.4
Үүнээс: Эмэгтэй	673	552	660	491	73.0	74.4
Магистр, доктор	6	8	7	1	16.7	14.3
Дээд боловсролтой	283	289	309	170	60.1	55.0
Тусгай дунд	134	110	96	33	24.6	34.4
Техник мэргэжлийн	116	122	106	63	54.3	59.4
Бүрэн дунд	382	373	682	643	168.3	94.3
Бүрэн бус дунд	129	115	80	66	51.2	82.5
Бага	29	20	13	11	37.9	84.6
Боловсролгүй	8	10	19	29	362.5	2.2 <sup>2</sup>

## 3.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 10 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017.X	2018.X	2017.X	2018.X	2017.X	2018.X
ДҮН	1312	1016	295	443	1244	2422
Айраг	69	17	22	31	77	169
Алтанширээ	28	36	0	10	22	94
Даланжаргалан	57	72	11	37	71	160
Дэлгэрэх	16	15	40	4	26	30
Иххэт	24	29	14	29	15	281
Мандах	19	16	2	71	50	113
Өргөн	36	23	19	26	79	108
Сайхандулаан	17	33	0	5	42	699
Улаанбадрах	27	16	46	46	50	41
Хатанбулаг	45	21	11	18	49	96
Хөвсгөл	14	9	17	16	34	66
Эрдэнэ	25	30	21	9	51	30
Сайншанд	684	560	65	98	496	410
Замын - Үүд	251	139	27	43	182	125

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 3.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 10 сарын эцэст

Салбарын ангилал	2017.Х	2018.Х
	Тоо	
Бүгд	652	617
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	12	10
Уул уурхай олборлох аж үйлдвэр	353	199
Боловсруулах үйлдвэрлэл	9	7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6	6
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4	9
Барилга	1	61
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1	1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		17
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		1
Мэдээлэл, холбоо	1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	10	15
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5	3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	54	58
Боловсрол	35	33
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	26	30
Урлаг, үзвэр,тоглоом наадам	9	11
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	126	155
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		1

## 3.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 10 сарын эцэст

Үзүүлэлт	2017. Х	2018. Х
	Тоо	
Бүгд	652	617
Менежер	9	11
Мэргэжилтэн	122	119
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	96	68
Контор, үйлчилгээний ажилтан	30	19
Худалдаа, үйлчилгээний ажилтан	76	56
ХАА, ой загас агнуурын ажилтан	2	3
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	72	32
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	112	87
Энгийн ажил мэргэжил	126	210
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	7	12

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



3.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 10 сарын эцэст

Үзүүлэлт	2017. X		2018. X	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	518	211	538	226
Менежер	11	2	11	7
Мэргэжилтэн	74	55	76	52
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	83	43	54	30
Контор, үйлчилгээний ажилтан	26	23	32	18
Худалдаа, үйлчилгээний ажилтан	70	52	56	41
ХАА, ой загас агнуурын ажилтан	3	1	1	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	46	6	29	8
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	92	6	72	11
Энгийн ажил мэргэжил	107	22	196	55
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	6	1	11	4

3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 10 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	#REF!	#REF!	#REF!	#REF!
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2		2	
Уул уурхай олборлолт	92	18	73	19
Боловсруулах үйлдвэрлэл	10	6	2	8
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	63	13	34	29
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	49	12	33	16
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	31	12	1	30
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16	13		16
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1		1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10	2	5	5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	2	7	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	26	8	3	23
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	5	5	5	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				



## ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-X 2017 I-X
	2017 I-X	2018 I-X	
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	22 281.4	26 668.1	119.7
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	13 384.2	16 782.3	125.4
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 516.9	1 902.8	125.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 553.5	4 428.4	97.3
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	2 214.6	2 782.6	125.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн	612.2	772.0	126.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	32 493.6	35808.0	110.2
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	23 057.4	26 949.9	116.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 813.9	2 111.9	116.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	5 061.6	4 030.4	79.6
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 796.0	2 022.3	112.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн	764.7	693.5	90.7

\*\* - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## 4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2017 I-X	2018 I-X	2018 I-X 2017 I-X
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	16830	17633	104.8
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	8274	9067	109.6
Төсөвт байгууллага	тоо	8556	8566	100.1
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	23706.5	27631.9	116.6
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	17437.8	19989.8	114.6
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	2554.3	3075.7	120.4
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	1193.8	1444.1	121.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	696.9	720.2	103.3
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1823.7	2402.1	131.7

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I-X	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-X
	2017 I-X	2018 I-X	2017I-X	2017 I-X	2018 I-X	2017 I-X
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>17796</b>	<b>23281</b>	<b>130.8</b>	<b>4717178.0</b>	<b>6647562.2</b>	<b>140.9</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1383</b>	<b>1363</b>	<b>98.6</b>	<b>1686189.2</b>	<b>1897575.7</b>	<b>112.5</b>
Ахмад настны тэтгэвэр	66	61	92.4	82950.0	83676.3	100.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1317	1302	98.9	1603239.2	1813899.4	113.1
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1223</b>	<b>1069</b>	<b>87.4</b>	<b>601772.2</b>	<b>631241.3</b>	<b>104.9</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1139	1006	88.3	559364.9	590828.3	105.6
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	55	51	92.7	31186.1	33628.8	107.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	8	6	75.0	3567.0	4901.3	137.4
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	12	5	41.7	5612.6	1818.9	32.4
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	2041.6	64.0	3.1
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>1025</b>	<b>1010</b>	<b>98.5</b>	<b>493893.1</b>	<b>523748.8</b>	<b>106.0</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	362	234	64.6	277928.4	319208.8	114.9
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	595	711	119.5	164764.7	118980.0	72.2
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	13	15	115.4	26000.0	30000.0	10 <sup>2</sup>
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	4	12	2 <sup>2</sup>	4800.0	14400.0	4.5 <sup>2</sup>
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	14	20	142.9	16800.0	24000.0	10 <sup>2</sup>
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		14			16800.0	
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>						
<b>5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал</b>	<b>7095</b>	<b>8621</b>	<b>121.5</b>	<b>897574.8</b>	<b>916159.2</b>	<b>102.1</b>
